

ЧУХАЛ МЭДЭГДЭЛ



Япон руу ургамал авч ороход Ургамлын хорио цээрийн гэрчилгээ шаардлагатай байдаг



Ургамал хамгааллын тухай хуулийн дагуу, Япон руу ургамал* авч орохын тулд **экспортлогч улсын төрийн байгууллагаас олгосон ургамлын хорио цээрийн гэрчилгээг (Phytosanitary certificate) хавсарга** импортын шалгалтад хамрагдах шаардлагатай байдаг.

Японд авч орохыг хориглосон ургамал ч байдаг (Арын хэсгийг үзнэ үү).

*Жимс, хүнсний ногоо, үр тарианаас гадна тайрсан цэцэг, үр, суулгац болон ургамлаар хийсэн зарим боловсруулсан бүтээгдэхүүнүүд ч хамрагдана.

Мөн ургамлын хорио цээрийн гэрчилгээ шаарддаггүй ургамал (гэхдээ импортын шалгалтад хамрагдах шаардлагатай) болон, ургамлын хорио цээрийн гэрчилгээ ба импортын шалгалтад хамрагдах шаардлагагүй ургамал ч байдаг (Арын хэсгийг үзнэ үү).



Ургамлын хорио цээрийн гэрчилгээгүй ургамлыг **ургамал хамгааллын тухай хуульд үндэслэн устгах арга хэмжээ авна.**

Ургамлын хорио цээрийн гэрчилгээгүйгээр импортолсон эсвэл импортлох үед үзлэгт хамрагдаагүй тохиолдолд **гурван жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 3 сая иен хүртэлх (хуулийн этгээд бол 50 сая иен хүртэл) торгууль**ноогдуулах тохиолдол байдаг.

**Ургамлын хортон шавьж
Нэвтрэн орохоос сэрэмжилж байна**

MAFF

Ministry of Agriculture,
Forestry and Fisheries
農林水産省



Японд авч орохыг хориглосон гол ургамлууд

- Газар дундын тэнгисийн жимсний ялаа, дорнын жимсний ялаа гарсан орон болон бүс нутгийн ихэнх жимс, хүнсний ногоо (жүржийн төрлийн жимс болон манго гэх мэт)
- Сагамхай дэнгийн эрвээхэй гарсан орон болон бүс нутгаас авчирсан алим, интоор зэрэг жимс, ястай хушга гэх мэт

*Үүнээс гадна Японд гараагүй ч дэлхий дахинд ноцтой хохирол учруулсан хортон шавж гарсан улс орон, бүс нутгаас олон тооны ургамлыг авчрахыг хориглосон байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг ургамал хамгааллын газраас лавлана уу.



Газар дундын тэнгисийн
жимсний ялаа



Дорнын
жимсний ялаа



Сагамхай дэнгийн
эрвээхэй

Ургамлын хорио цээрийн гэрчилгээ шаарддаггүй ургамал (гэхдээ импортын шалгалтад хамрагдах шаардлагатай)

Нунтаг чинжүү, япон чинжүү, хэрчиж хатаасан цагаан лууван, тагнай өвс, эмийн зориулалттай лууван, бадамлянхуаны үр, одны гоньд, кофены шош, наранцэцгийн үр (хүнсний зориулалттай) зэрэг хатаасан эсвэл хөлдөөсөн бүтээгдэхүүн байх бөгөөд тариалалт, тэжээл, бордоо, хөдөө аж ахуй, ойн аж ахуйн үйлдвэрлэлийн материалд ашиглагддаггүй зүйл байна.

*Жич: Үр тариа (будаа, шар будаа, эрдэнэ шиш, гурвалжин будаа, улаан буудай гэх мэт), буурцагт ургамал (шар буурцаг, улаан шош, газрын самар гэх мэт), мод, какаоны шош, гүнждийн үр, хатаасан вандуй, гашниз, зарим хатаасан цэцэг, тан, халуун ногоо гэх мэт хатаасан бүтээгдэхүүн байсан ч ургамлын хорио цээрийн гэрчилгээ хавсаргах шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг ургамал хамгааллын газраас лавлана уу.

Ургамлын хорио цээрийн гэрчилгээ хавсаргах ба импортын шалгалтад хамрагдах шаардлагагүй зүйлс

- Боловсруулсан мод
- Боловсруулсан цай
- Спирт, цууны хүчил, элсэн чихэр зэрэгт дэвтээсэн ургамал гэх мэт

Ургамал хамгааллын газрын гол лавлах газрууд

● **Ёкохамагийн ургамал хамгааллын газар**

+ 8 1 — 4 5 — 2 1 1 — 7 1 5 3

● **Нагоягийн ургамал хамгааллын газар**

+ 8 1 — 5 2 — 6 5 1 — 0 1 1 2

● **Кобэгийн ургамал хамгааллын газар**

+ 8 1 — 7 8 — 3 3 1 — 2 3 8 6

● **Можигийн ургамал хамгааллын газар**

+ 8 1 — 9 3 — 3 2 1 — 2 6 0 1

● **Нахагийн ургамал хамгааллын газар**

+ 8 1 — 9 8 — 8 6 8 — 2 8 5 0